



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2020 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

АУДИТЫН КОД: САГ-2021/79/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор Б.Сэржмядаг
Утас: 261628 Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn
Аудитыг гүйцэтгэсэн: "Амгалан Ахуй Аудит" ХХК
Утас: 77401919 Цахим хаяг: amgalanahui.audit@gmail.com

Улаанбаатар хот
2021 он

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	12
3.Аудитын тайлан.....	13
3.1. Ерөнхий зүйл.....	13
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	13
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт.....	14
3.4. Материаллаг байдал.....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	15
3.6. Зорилтот түвшний төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	17
3.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа.....	19
3.8. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.9. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.10. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	20
3.11. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	21
4. Менежментийн захидал.....	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	24



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ОЧИРБАТ ТАНАА

2021.03.15 № 07/904
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан материаллаг алдаагүй, Нягтлан бодох бүртгэлийн туха хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн үнэн зөв, шударг толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын оло улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангий аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бу аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулса хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлаг хүлээнэ. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020 оны гүйцэтгэлий төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлт нь нийт 5 зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэс хөтөлбөр, тэдгээрийн гүйцэтгэлийг хангах 10 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснө хэрэгжилт 94.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүги тайлагналын олон улсын стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шудаг бэлтгэж толилуулах үүрэгтэй.